



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/336

Хэрлэн сум

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", 29.1.6-ын "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний эрсдэл бүхий Галшар, Баянхутаг, Баянмөнх, Дархан, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Мөрөн, Хэрлэн, Бор-Өндөр сумдын малыг вакцинжуулах ажлыг 06 дугаар сард багтаан зохион байгуулсугай.

2. Вакцинжуулалтын ажилд Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн, багийн Засаг дарга, төрийн албан хаагчдыг томилон ажиллуулж, уг ажлыг шуурхай, чанартай зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж, вакцинжуулалтын чанар, явц, гүйцэтгэлд хяналт тавьж, тарилгын дүнг танилцуулж, санхүүжилтийн баримт материалыг холбогдох яаманд хугацаанд нь хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА